

БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ СУРАЛЦАГЧДЫН ДАСАН ЗОХИЦОХ БАЙДЛААР ҮНЭЛЭХ НЬ

Г. Нямсүрэн
Доктор (Ph. D.)

Хөдөө аж ахуйн их сургууль
Эдийн засаг, бизнесийн сургууль

nyamsuren_g@muls.edu.mn

Хураангуй: Аливаа улс орны хөгжил, ард иргэдийн хангалуун амьдрал нь тухайн орны боловсролын тогтолцоог хөгжүүлэхтэй нягт холбоотой байдаг. Улс орны нийгэм, шинжлэх ухаан, эдийн засаг, техникийн дэвшил зэрэг асуудлыг цаг тухайд нь оновчтой шийдвэрлэх нийтлэг нөхцлийн нэг бол тухайн орны иргэдийн боловсролын чадавхи юм. Суралцагчид, эцэг, эхчүүд боловсролын байгууллагатай шууд харилцаж байдаг ч тухайн байгууллагын үйлчилгээнд нөлөөлөх боломж хомс байдаг. Боловсролын үйлчилгээ нь иргэдийн эрэлт хэрэгцээнд тэр бүр нийцэхгүй байх нь түгээмэл ажиглагддаг. Боловсролын үйлчилгээ нь сургалт эрхэлсэн боловсролын байгууллагын суралцагчдад эрдэм мэдлэг эзэмшүүлж, цогц чадамж төлөвшүүлэх үйл явц юм. Боловсролын үйлчилгээний хүртээмж гэдэг ойлголтыг сургалтын үр дүн, өгөөжийг илүүтэй анхаарч авч үзэх бөгөөд сайжруулахын тулд зөвхөн хэрэглэгчдийн үнэлгээг тогтмол цаг хугацаанд авч хэвшин тэдний хэрэгцээ, санал бодлыг тусгах нь үр дүнтэй. Тиймээс ч боловсролын үйлчилгээний онол арга зүй асуудалд дүн шинжилгээ хийж, боловсролын үйлчилгээ нь суралцах үйл явцын хэсэг үр дүн бөгөөд үүний дүнд байгууллагад гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах стратеги өөрчлөлт явагдана. Иймд талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар гүйцэтгэлийг сайжруулах явдал чухал. Ялангуяа их, дээд сургуулийн шаардлагад оюутан хэр нийцсэн болохыг илтгэх гол үзүүлэлт нь оюутны дасан зохицол юм. Их, дээд сургуульд орох шилжилт нь шинэ орчинд дасан зохицохыг шаарддаг. Энэ нь том дарамт болж ирдэг байна. Судалгааны ажлуудаас үзэхэд эдгээр өөрчлөлт нь шинэ, танихгүй орчин, гэр бүл, найз нөхдөөс хол байх, ганцаардал, ялгаварлагдсан мэт мэдрэмж төрөх, сэтгэл дотроо өөрсөдтэйгээ зөрчилдөх, санхүүгийн дарамт зэрэг байдлаар илрэх ба 1-2 курсын суралцагчдад түлхүү илэрнэ. Хэрэв тухайн оюутан эдгээрт дасан зохицож чадахгүй бол сэтгэл гутрах, сурлага буурах, хичээлд идэвх болон дур сонирхолгүй болох, хичээл завсардах, цаашлаад их дээд сургуулийг орхих хүртэл даамжирдаг. Тиймээс ч боловсролын үйлчилгээний хүртээмж нь оюутны дасан зохицох үйл явцаас хамааралтай болохыг тодорхойлон авч үзэв.

Түлхүүр үгс: Боловсролын үйлчилгээний хүртээмж, оюутны дасан зохицохуй

УДИРТГАЛ ХЭСЭГ

Иргэд илүү сайн боловсролын үйлчилгээг хүсэж байгаагаа хэрхэн илэрхийлэх, боловсрол нь иргэдэд хэр хүртээмжтэй байгаа, багшлах боловсон хүчин, ажилтаны ур чадвар, харилцааны соёл,

шаардлага хангаж байгаа эсэх, үйлчилгээг сайжруулахад иргэдийн санал бодол, мэдээлэл ямар ач холбогдолтой зэрэг асуудлуудад хариулт учир дутагдалтай байдаг. Их сургуульд орсон эхний жил оюутнуудад ихээхэн бэрхшээл тулгардаг үүнд орчин нөхцөл

өөрчлөгдсөн, хувийн зан чанарын онцлог гэх мэт олон зүйл нөлөөлдөг. Үүнээс үүдэлтэй ихэнх нь буруу сонголт хийсэндээ харамсан өөр салбарыг сонгохоор сургуулиас гарах зэрэг шалтгаан болдог. Карен Хорни хэвийн дасан зохицохын тулд хүн өөрийн “би”-г танин мэдэж өөрийн доторх туйлын дүрийг зөв илрүүлэх хэрэгтэй гэж үзсэн байдаг. Тэрээр бие хүний дотоод зөрчлүүд нь хүний амьдарч байгаа соёл иргэншлээс тодорхой хэмжээгээр шалтгаалдаг гэж үзсэн. Өөрөөр хэлбэл хуучин ба шинэ үүссэн үнэт зүйлүүд зөрчилдсөнөөр амьдралын янз бүрийн хэв маяг бий болж үнэт зүйлсийн баримжаанд зөрчил үүсч түгшүүрт ордог. Их дээд сургуульд суралцах явц нь хувь хүний амьдралын хамгийн дарамт ихтэй үеүүдийн нэг гэж тооцогддог байна. Оюутнууд энэ үед дэмжлэг туслалцаа бага авахын зэрэгцээ үүрэг хариуцлага болон дарамтууд ихсэнэ.

2001 онд судлаач Жоди Залл Кукос “Гүйцэтгэлд тулгуурласан хянах, үнэлэх системийг бий болгох нь” бүтээлдээ төрийн үйлчилгээний бодит байдлыг иргэдийн оролцоотойгоор үнэлэх боломжтой [1] гэж судалж үзсэн байдаг.

Судалгааны зорилго:
Боловсролын үйлчилгээний хүртээмжийг суралцагчдын дасан зохицох байдлаар үнэлэх асуудлыг тодорхойлох.

Судалгааны зорилт:

1. Боловсролын үйлчилгээ, хүртээмж, тодорхойлох үзүүлэлтийг судлах.

2. Боловсролын үйлчилгээний хүртээмжийг суралцагчдын дасан зохицох байдлаар үнэлэх асуудлыг тодорхойлох. /ХААИС, ШАУИС-ийн жишээ дээр/

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Боловсролын үйлчилгээний хүртээмж гэдэг ойлголтыг авч үзэхийн өмнө боловсрол, үйлчилгээ гэсэн ухагдахуунуудын ойлголтыг авч үзье. Боловсролын талаарх эрдэмтдийн тодорхойлсныг үзвэл: Боловсрол нь хүмүүсийн сурах хэрэгцээг хангахад чиглэсэн системтэй үйл ажиллагааг багтаана. Боловсрол гэдэг нь аливаа зохион байгуулагдсан системтэй харилцааг хэлнэ[2]. Боловсрол нь байгаль, нийгэм-хүмүүнлэг, сэтгэцийн шинжлэх ухаан, техник үйлдвэрлэлээс болон амьдрал орчноос эзэмшсэн мэдлэг, чадвар, дадал, туршлагын нэгдэл, энэ бүхнийг бий болгох үйл явц юм. Тухайн насны суралцагсдад төлөвшин тулгуур мэдлэг, хүмүүнлэг харилцаа, амьдрах ерөнхий арга чадварын цогц юм [3]. Боловсрол нь иргэн төлөвшүүлэх үүрэг бүхий нийгмийн институт юм [4]. Боловсрол нь хүн төрөлхтний амьдрах ухаан, соёлыг үеэс үед дамжуулж байгаа нийгмийн үзэгдэл, байгаль нийгмийн орчинд амьдрах чадвар,

ухаан өөрөөр хэлбэл: шинэ мэдлэг, үзэл санаа, дадлага, чадвар, хандлагыг эзэмшүүлж, түүнийгээ насан туршдаа хэрэглэх үйл явц [5] зэргээр судлаачид тодорхойлсон. Боловсролын процесс гэдэг нь бодгалийн төрөлх чанар, авъяас билэг хөгжих замаар, орчны бүх хүчин зүйлийн нөлөөгөөр, түүнчлэн чиглэсэн зорилго төлөвлөгөө, тодорхой арга хэлбэр бүхий зохион байгуулалттай сургалтын үр дүнд нийгмийн иргэн төлөвших үйл явц юм [6]. Эндээс үзэхэд судлаачид боловсрол гэдгийг тодорхойлохдоо нийгмийн үзэгдэл, бие хүн төлөвших, мэдлэг боловсрол эзэмших үйл явц, үр дүн нь тухайн хүнд төлөвшсөн тулгуур мэдлэг, чадвар дадал, арга ухаан бүхий үйл явц, боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа гэсэн үндсэн чиглэлүүдээр авч үзсэн байна. Гэвэл үйлчилгээ талаас нь тодорхойлохдоо “хүний хэрэгцээг хангах зорилгоор зах зээлд нийлүүлж буй бүх зүйлийг бүтээгдэхүүн, үйлчилгээ гэж нэрлэдэг” [7] гэжээ. Мөн “Үйлчилгээ гэдэг нь үйл ажиллагааны ба баялагийн нэг төрөл. Үйлчилгээг нэг тал нь нөгөөдөө үзүүлдэг бөгөөд тэр нь өртөгдөхгүй юм уу үр дүн нь харилцагчийн өмч болдоггүйгээрээ онцлог юм”[8]. Боловсролын үйлчилгээ гэдэг нь хүн төрөлхтний амьдрах ухаан, соёлыг үеэс үед дамжуулу байгаа нийгмийн үзэгдэл, байгаль нийгмийн орчинд

амьдрах чадвар өөрөөр хэлбэл шинэ мэдлэг, үзэл санаа, дадлага, чадвар хандлагыг эзэмшүүлж түүнийгээ насан туршдаа сэлбэн хэрэглэх, энэхүү капиталыг хүнд хөгжүүлж төлөвшүүлэх тодорхой зорилго, чиглэл, төлөвлөлт, зохион байгуулалт бүхий үйл явц мөн [9] гэх зэргээр авч үзсэн. Боловсролын үйлчилгээ нь сургалт эрхэлсэн боловсролын байгууллагын суралцагчдад эрдэм мэдлэг эзэмшүүлж, цогц чадамж төлөвшүүлэх үйл явц бөгөөд энэ нь чиг үүргээсээ эхлээд өөрийн өвөрмөц шинж, онцлогтой. Боловсролын хүртээмж гэдэг нь суралцагчдын хувьд албан ба албан бус боловсролын үйл ажиллагаа, суралцагчдада ялгаваралгүй хандах аюулгүй сурах үйл ажиллагааг дэмжсэн орчинг бүрдүүлэх зэрэг хамаарагдана. Сургах системийн хувьд хүртээмж нь бодлогоор дэмжиж, зохицуулалт хийх, орлогыг хуваарилах, сургалтын үр дүнг хэмжих байдлаар илэрдэг. Боловсролыг нийгмийн эрэлт бараа болгон авч үзэх явдал. Өөрөөр хэлбэл: эцэг эх, сурагчдын эрэлт хэрэгцээ болон сургууль, сурган хүмүүжүүлэх байгууллагууд нь эцэг эх, сурагчдын эрэлт хэрэгцээг хангах байдал гэсэн хоёр талаас авч үзнэ [10]. Энэ бүхнээс үзэхэд боловсролын хүртээмж гэдэг ойлголт нь сургуульд хамрагдалт, сургалтын гадаад ба дотоод орчин зэргийн агуулсан өргөн ойлголт юм.

Аливаа үйлчилгээ хэрэглэгчдийн сэтгэл ханамжтай байдлаар хэмжигддэг. Өнөө үед хэрэглэгчид өөрсдөө төрийн үйлчилгээний хүртээмжид үнэлгээ хийж, үнэлэлт өгөхөд нөлөөлөхийн зэрэгцээ үйлчилгээний стандартыг тогтоох, шийдвэр гаргах явцад идэвхитэй оролцох сонирхолтой болсон. Хэрэглэгчийн сэтгэл ханамжтай байдлаар үйлчилгээний үр дүнг тооцон хариуцлагын тогтолцоог бий болгох зэргээр улсын салбарт буюу төрийн үйлчилгээний гүйцэтгэлд бодитой хандах алхамууд хийгдсэнээр улс орныхоо нийгэм эдийн засгийн хөгжилд нөлөөлж, хүний эрх, эрх чөлөөний баталгааг бүрдүүлэх, хүний аюулгүй байдлыг хангахад чухал нөлөө үзүүлнэ [11]. Энэ бүхнээс үзвэл боловсролын үйлчилгээний хүртээмж нь байгууллагын суралцах үйл явцын үр дүн бөгөөд үүний үр дүнд гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах стратегийн өөрчлөлт явагдана. Боловсролын үйлчилгээний хүртээмжийн тухай асуудалд багш нарын тухай ярихгүй өнгөрч болохгүй. Ямар ч нийгэмд боловсролын хүртээмжийг сайжруулах нь багш нар чухал үүрэгтэй. Тиймээс ч багш нь ямар зорилгод хүрэхээ мэддэг байх, заах материалынхаа талаар тодорхой мэдлэг, хэрэглэх чадвартай. нэг болон түүнийс дээш заах аргатай, ажиллах хүсэл, сонирхолтой, боловсролын чанартай хүргэхэд шаардлагатай материаллаг баазаар

хангагдсан байх зэрэг олон хүчин зүйлээс шалтгаална. Гэвч оюутнаас хамааралтай хүчин зүйл нь түүний хэр зэрэг хурдан дасан зохицох байлдаас сургалтын үр дүн ихээхэн хамаарна. Хүн бүр давтагдашгүй, өөр өөрийн ахин дэвших боломжтой үеүүдтэй учраас тухайн нөхцөлд зохистой хөгжүүлэх, чиглүүлэх үйл явц чухал байдаг.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Боловсролын үйлчилгээний хүртээмж, үр дүнгийн үндсэн үзүүлэлтийг оюутны дасан зохицол, сэтгэл ханамжын байдлаас судлан үзлээ. Бидний мэдэхээр ерөхий боловсролын сургуулиас дөнгөж гарсан шинэхэн оюутнууд их, дээд сургуульд маш өндөр сэтгэгдэлтэйгээр орж ирдэг бол энэ нь төд удалгүй суларч, өөртөө итгэх итгэлгүй болох ба багш болон бусад суралцагчиддаа итгэхгүй, сурах сонирхол буурах, хандлага өөрчлөгдөх зэргээр сөрөг нөлөө дагуулж байна. Өнөөдөр оюутнуудын маань дасан зохицол хэр байгаагаас хамааран сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүн хамаарч байна. Хэд хэдэн түгээмэл хэрэглэгддэг аргуудаас 1989 онд Robert W. Baker болон Bohdan Siryk нарын гаргасан SACQ /Student Adaptation to College Questionnaire/ –оюутны дасан зохицлын асуулга гэх 67 асуулгатай тестийг сонгон авсан. Асуулт бүрийн харгалзах оноо ялгаатай бөгөөд тухайн асуулт надад бүрэн тохирч санал нийлж

байна гэвэл хамгийн дээд оноог, огт санал нийлэхгүй байна гэвэл 0 оноо, харин дунд зэрэг гэвэл харгалзах оноог авна. Асуулга нь эерэг болон сөрөг хэлбэрээр тавигдсан байна. Оюутан тус бүрийн нийт авах оноо 437. Асуулгын үр дүнг боловсруулахдаа R програм болон Matlab програмуудыг ашиглан гаргасан.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Судалгааны ажлын зорилготой уялдуулж ХААИС болон ШАУИС-ийн 2018-2019 оны хичээлийн жилийн 1-р курсын нийт 85 оюутан хамрагдсан. ШАУИС-ийн хувьд 9 нь эрэгтэй, 40 нь эмэгтэй буюу нийт 50 оюутан. Харин ХААИС-ийн 34 нь эрэгтэй, 11 нь эмэгтэй буюу нийт 45 оюутан хамрагдсан. Нийт оролцогчдын 53.2% нь эмэгтэй 46.8% нь эрэгтэй байв.

1. Сургууль тус бүрийн дасан зохицлын статистик үзүүлэлт:

Энэ хэсэгт бид дасан зохицлыг сургууль тус бүрийн хувьд тооцоолон гаргасан.


Хүснэгт 1. ХААИС болон ШАУИС тус бүрийн оюутнуудын дасан зохицлын статистикийн үзүүлэлт

	Сургууль	Дундаж утга	Стандарт хазайлт	Хувиар
Нийт дасан зохицлын утга (437)	ХААИС	274,6	34,7	62,8
	ШАУИС	286,6	51,7	65,5
Академик дасан зохицол (180)	ХААИС	117	16,1	65,0
	ШАУИС	123,9	23,7	68,3
Нийгмийн дасан зохицол (115)	ХААИС	67,3	10,7	58,5
	ШАУИС	72,7	13,8	63,2
	ХААИС	46	11,4	54,7

Хувь хүний дасан зохицол (84)	ШАУИС	46,1	14	54,8
Их сургуулийн талаарх үзэл бодол (58)	ХААИС	44,2	10	76,2
	ШАУИС	43,8	12	75,5

Дээрх хүснэгтээс харахад аль аль сургуулийн хувьд нийт дасан зохицол нь дунджаас нилээд дээгүүр буюу 10-аас илүү хувьтай байна. Үзүүлэлт бүрийг задалж харвал Академик болон ИДС дасан зохицол нь дунджаас нилээд өндөр харин хувийн дасан зохицол нь дунджаас дөнгөж дээгүүр байсан ба бусад үзүүлэлттэй харьцуулбал бага байгаа нь харагдаж байна. Түүнчлэн ХААИС, ШАУИС-ийн академик, хувийн, ИДС-ийн дасан зохицлын үзүүлэлтүүд нь хоорондоо их ойролцоо байна. Харин нийгмийн дасан зохицлын хувьд дээрх 2 сургуулийн үзүүлэлт нь бусад үзүүлэлтээ бодвол бага зэрэг ялгаатай байна. ХААИС болон ШАУИС-ын оюутнуудын дасан зохицлын түвшинг хувиар график 1-т харуулав.

График 1. ХААИС болон ШАУИС-ийн оюутнуудын дасан зохицлын түвшинг хувиар илэрхийлсэн байдал.



Энэ графикаас харахад нийт үзүүлэлт, академик, нийгмийн үзүүлэлтүүдийн хувьд ШАУИС нь тун бага хувиар илүү байна. Ерөнхийд нь харахад ХААИС болон ШАУИС-ийн оюутнуудын хооронд

дасан зохицлын хувьд төдийлөн их ялгаа харагдахгүй байна.

2. Хүйсийн хувьд дасан зохицлын статистик үзүүлэлт:


Энэ хэсэгт бид дээрх хоёр сургуулийн судалгаанд оролцсон бүх оюутнуудыг хүйсийнх нь хувьд статистик үзүүлэлт гаргасан.

Хүснэгт 2. Нийт оюутнуудын дасан зохицлын статистик утга

Утга (нийт харгалзах оноо)	Хүйс	Дундаж утга	Дундаж %	Стандарт хазайлт	t – утга	p – утга
Нийт (437)	Эрэгтэй	273,8	62,6 %	36,6	1,39	0,16
	Эмэгтэй	286,2	65,5 %	49,6		
Академик (180)	Эрэгтэй	117,3	65,2 %	16,4	1,43	0,15
	Эмэгтэй	123,2	68,4 %	23,2		
Нийгмийн (115)	Эрэгтэй	69,5	60,4 %	10,7	0,41	0,68
	Эмэгтэй	70,6	61,4 %	14		
Хувийн (84)	Эрэгтэй	45,7	54,4 %	10,3	0,22	0,8
	Эмэгтэй	46,3	55,1 %	14,5		
ИДС-ийн (58)	Эрэгтэй	41,2	71 %	11,3	2,1	0,03
	Эмэгтэй	46,1	79 %	10,5		

Эндээс харахад ИДС-ийн дасан зохицлын хувьд нилээд өндөр хувь буюу эрэгтэй оюутнууд 71%, эмэгтэй оюутнууд 79% гарсан хэдий ч *p*-утга 0.05-аас бага байгаа нь бидний судалгаанд их хэмжээгээр биш ч гэсэн 7 оюутан хэт бага оноо авсан харин үлдсэн хэсэг оюутнууд нь дунджаас нилээн дээгүүр оноо авсантай холбоотой юм. Нэг бол тэр 7 оюутны ИДС-ийн дасан зохицол дээр нь анхаарах хэрэгтэй эсвэл эдгээр оюутнуудыг дахин магадлах шаардлагатай нь харагдаж байна. Хүйсийн хувьд дасан зохицлын хувийг график 2-т үзүүлэв.

График 2: Оюутнуудын дасан зохицлыг хүйсээр авч үзсэн байдал



Дээрх графикаас харахад эрэгтэй болон эмэгтэй оюутнуудын хувьд хэт их ялгаа гараагүй бөгөөд академик болон ИДС-ийн хувьд эмэгтэй оюутнууд арай их гарсан үзүүлэлттэй байна.

3. Нийт оюутнуудын дасан зохицлын үзүүлэлтийн түгэлт:


Энэ хэсэгт бид дээрх хоёр сургуулийн судалгаанд хамрагдсан бүх оюутнуудын дасан зохицлын үзүүлэлтийг харуулсан. Шапиро Вилкийн нормаль түгэлтийг шалгах тестээр судалгаанд оролцогчдын дасан зохицлын бүх утгуудыг шалгасан үр дүнг хүснэгтэнд үзүүллээ.

Хүснэгт 3. Шапиро Вилкийн тестийн үр дүн


Нийт	Академик	Нийгмийн	Хувийн	ИДС-ийн
<i>p</i> =0,09	<i>p</i> =0,28	<i>p</i> =0,73	<i>p</i> =0,48	<i>p</i> =0,0003

p – утга нь 0,05 аас их гарсан утгууд нь нормаль түгэлтийн зарчмыг хангана гэж үзнэ. Мөн түүнчлэн тухайн үзүүлэлтийн гистограм ба Q-Q нормаль плотыг график 3-7-д харуулав.

График 3. Нийт оюутнуудын дасан зохицол /Нийт утгаар /. а) гистограм б) Q-Q плот




а)




б)

График 4. Нийт оюутнуудын дасан зохицол /Академик түвшин/. а) гистограм б) Q-Q плот




а)




б)

График 5. Нийт оюутнуудын дасан зохицол /Нийгмийн түвшин/. а) гистограм б) Q-Q плот




а)




б)

График 6. Нийт оюутнуудын дасан зохицол /Хувийн түвшин/. а) гистограм б) Q-Q плот




а)




б)

График 7. Нийт оюутнуудын дасан зохицол / ИДС-ийн дасан зохицол / а) гистограм б) Q-Q плот



а)



б)

4. Дотуур байранд амьдардаг оюутнуудын дасан зохицлын үзүүлэлт:

Бид судалгааны асуулгын 26-д хэрэв амьдардаггүй бол энэ асуултанд хариулахгүй хоосон орхихыг тусгасан. Үүнээс хэдэн оюутан дотуур байранд амьдардаг болохыг тогтоосон.

Нийт судалгаанд оролцсон оюутнуудын 13,8 % нь дотуур байранд амьдардаг бөгөөд эдгээр оюутнуудын дасан зохицлын түвшинг тусад нь авч үзүүлэв.

Хүснэгт 3. Дотуур байранд амьдардаг оюутнуудын дасан зохицол

	Академик	Нийгмийн	Хувийн	ИДС	Нийт
Оноо		73,3076	38,923	37,846	259,07
о	109	9	08	15	69
Хувь (%)	60,5	63,7	46,3	65,2	59,2

Дээрх хүснэгтээс харахад дотуур байранд амьдардаг оюутнуудын хувьд Академик

болон нийгмийн мөн их, дээд сургуулийн дасан зохицлын үзүүлэлт дунджаас 10 гаран хувиар их байна. Харин Хувийн дасан зохицлын хувьд дунджаас бага байгаа нь ажигдагдаж байна. Эндээс дүгнэхэд оюун санааны болон эрүүл мэндийн хувьд доогуур байгаа нь харагдаж байна. Энэ тал дээр нь анхаарах шаардлагатай юм. Эдгээр утгуудыг нийт оюутнуудын дасан зохицлыг хувиар илэрхийлсэн утгуудтай харьцуулсан үр дүнг график 8-д үзүүлэв.

График 8. Харьцуулсан үр дүн




График 8-аас харахад дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн нийгмийн дасан зохицлоос бусад бүх үзүүлэлт нь нийт оролцогчдын дундаж үзүүлэлтээс доогуур байна. Энэ талууд дээр нь анхаарах ёстой. хүрээнд гарсан өгөгдлөөс эдгээр оюутнуудын дасан зохицол хэр түвшинд байгааг, сургуулиас хамаарч буй эсэх, үүнээс гадна хүйсийн хувьд ямар ялгаа гарч байгааг илрүүлэх судалгаа хийсэн. Нийт судалгаанд хамрагдсан оюутнуудын тоо 94, үүнээс 53.2%

нь эмэгтэй 46.8% нь эрэгтэй байсан.

ДҮГНЭЛТ

Улс орны хөгжлийг тухайн орны хүний хөгжлийн үзүүлэлтээр хэмждэг. Хүний хөгжлийн үзүүлэлт нь тухайн орны боловсролын үйлчилгээний хүртээмж, хүн амын боловсрол эзэмшсэн байдал, амьдрах арга барилд суралцсан байдал зэргээр тодорхойлогддог. Боловсролын үйлчилгээний хүртээмж гэдэг ойлголт нь сургуулийн хамрагдалт, сургалтын гадаад, дотоод орчин зэрэг ойлголтуудыг өөртөө агуулсан өргөн ойлголт хэдий ч боловсролын үйлчилгээний хүртээмжийг сайжруулахдаа суралцагчийн сургуульдаа хэр дасан зохиож, үр дүнтэй суралцах сэтгэл зүйг анхаарах нь нэг чухал үзүүлэлт юм.

1. Суралцах, сургах арга барил өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаатай холбогдуулан өнөөдөр бага ангиас дунд анги руу, ахлах ангиас их дээд сургууль руу, их[1] дээд сургуулиас ажлын байр, нийгэмд гарч байгаа боловсон хүчнүүдийн хоорондын уялдаа холбоо, зохилдолгоо, зохицол дутуу дулимаг харагдаж байна. Дасан зохицох чадварын түвшин доогуур үзүүлэлт бүхий оюутнууд багахан хувийг эзэлж байгаа ч энэ асуудал дээр нь багш нар чиглүүлэн ажиллах шаардлагатай гэж үзэж байна. Оюутан ахуй цагтаа хангалттай сайн дасан зохиож бие

дааснаар нийгэмд гарч ажиллаж, амьдрах, асуудал шийдвэрлэх, тэдгээрийг даван туулах, амжилт гаргахад нь түлхэц болдог.

2. Боловсролын үйлчилгээ, түүний хүртээмжийг сайжруулахын тулд бодлого боловсруулагчид, сургалтын байгууллага үйл ажиллагаагаа шинэчлэх нь хангалттай бус харин суралцагчид ямар байдлаар сургалтын үйл явц, орчиндоо дасан зохицох арга барилаа олж авч байгаа, хэрэгцээ хандлагыг үйл ажиллагаандаа тусгах асуудлаар доривтой өөрчлөлт гарахгүй байна гэсэн дүгнэлийг хийж байна. Өөрөөр хэлбэл: Сургуулийн зүгээс онцгойлон чиглүүлдэггүй учраас сургууль хооронд ялгаа утга тус бүр дээр ойролцоогоор 3-5 орчим хувийн ялгаа харагдаж байгаа нь бодит ялгаа болж чадахгүй байна.

НОМ ЗҮЙ

1. Jody Zall Kusak. Building performance based monitoring and evaluation system. Evaluation Journal of Australia. Vol 1. №26 2001.pp14-236
2. Батхуяг С., Батдэлгэр.Ж., Боловсролын судлалын ерөнхий үндэс. Улаанбаатар: 1999, X. 9.
3. Жамц Л., Боловсрол судлалын үндэс. Улаанбаатар: 1999.
4. Дмитриенко В. А., и др., Образование как социальный институт. Крас., 1989,
5. Наранчимэг Н., Боловсролын шинэчлэл сургалтын технологийн удирдлага. Улаанбаатар: 1999, X. 5.
6. Бүжидмаа Ж., Боловсролын философи. Улаанбаатар: 2002, X 109.
7. Баярмаа Д., Маркетинг. Улаанбаатар: 2006, X. 200.
8. Жаргалсайхан С., Маркетингийн тайлбар толь. Улаанбаатар: 1991, X. 17.

9. Наранчимэг Н., Орон нутаг дахь боловсролын хөгжлийн удирдлага. Улаанбаатар: 2002, Х. 8.
10. Land Pritchett. J. Access to Education. In Global Solutions, Cambridge University. 2004, PP. 175.
11. Увш П., Удвал В. Иргэдэд үзүүлж буй улс төрийн үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын хандлага. Улаанбаатар: 2005. Х. 20.
12. Lauterbach D., Koch E.I., Porter K. The Relationship between Childhood Support and Later Emergence of PTSD // Journal of Traumatic Stress. 2007, Vol. 20, № 5, October, PP. 857-867.
13. Nader K.O. Treatment Methods for Childhood Trauma // Treating Psychological Trauma and PTSD. Ed. by J.P. Wilson, M. Friedmann, J. Lindy. New York: «Guilford Press», 2001, PP. 278-334.